# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/357 Номгон

Төслийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны А/113 дугаар тогтоол "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.5.7 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/37 дугаар "Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай" тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу байгуулагдсан "Төсөл сонгон шалгаруулах дэд хороо"-ны 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн эрэмбэлсэн, 10 аж ахуйн нэгжийн 1,200,000,000 /Нэг тэрбум хоёр зуун сая/ төгрөгийн төслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн жагсаалтад багтсан аж ахуйн нэгжийн мэдээлэл болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар ирүүлсэн төсөл, олгосон зээлийн тайлан мэдээллийг нэгтгэн журамд заасан хугацаанд Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлэхийг дэд хороо (У.Балжинням)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

64?310913

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын
30-ны өдрийн А/357 дугаар захирамжийн хавсралт

# ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ЖАГСААЛТ

| № | Сумын нэр | ААН-ийн нэр | Регистр дугаар | Салбар чиглэл | Шинээр бий болох ажлын байрны тоо | Урьдчилсан судалгаа (оноо) | Нарийвчилсан судалгаа (оноо) | Дэд хороо (оноо) | Онооны нийлбэр | Хүссэн мөнгөн дүн | Шийдвэрлэсэн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | Богд | Тэргүүн богд хайрхан ХХК | 3127699 | Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах | 3 | 90.93 | 75.6 | 94.8 | 87.1 | 99,800,000 | 89,800,000 |
| 2 | Баянхонгор | Даяар трейд ХХК | 2605503 | Хүлэмжийн аж ахуй-Мод, жимс, хүнсний ногооны үр үрсэлгээ | 5 | 90.1 | 76.9 | 92.8 | 86.6 | 295,000,000 | 285,000,000 |
| 3 | Баянхонгор | Ингүүмэл баян ХХК | 3137015 | Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | 2 | 90.09 | 78.4 | 89.8 | 86 | 98,000,000 | 88,000,000 |
| 4 | Жинст | БШЛ ХХК | 3122913 | Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх | 3 | 89.8 | 73.5 | 92.2 | 85.1 | 90,000,000 | 90,000,000 |
| 5 | Баянхонгор | Сонголт трейд ХХК | 2551179 | Арвайтай цай үйлдвэрлэх | 5 | 87.8 | 73.6 | 91.2 | 84.2 | 300,000,000 | 245,000,000 |
| 6 | Өлзийт | Баяндэлгэрэх хайрхан ХХК | 3123049 | Хүлэмжийн аж ахуй-Мод, жимс, хүнсний ногооны үр үрсэлгээ | 3 | 90.6 | 73.9 | 86.4 | 83.6 | 86,863,000 | 76,863,000 |
| 7 | Галуут | ЛЭМЭ ХХК | 3131289 | Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах | 3 | 90.28 | 72 | 85.2 | 82.4 | 200,000,000 | 120,000,000 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Баянхонгор | Бага Шаргалжуут ХХК | 2605775 | Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах | 3 | 88.55 | 70.5 | 86.2 | 81.7 | 80,000,000 | 80,000,000 |
| 9 | Баянхонгор | Бархас-од нөхөрлөл | 3135721 | Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | 2 | 89.8 | 70.9 | 81.2 | 80.6 | 91,000,000 | 45,000,000 |
| 10 | Баянлиг | Лигүүн жигүүр ХХК | 3138534 | Хүлэмжийн аж ахуй-Мод, жимс, хүнсний ногооны үр үрсэлгээ | 5 | 89 | 70.3 | 71.8 | 77 | 99,717,380 | 80,337,000 |
| Дүн-10 | | | | | 34 | | | | | 1,440,380,380 | 1,200,000,000 |

--oOo--